

# Олон улсын харилцаа

**БАГШ:Д.ОЮУН**

# Сэдэв 9: Олон улсын харилцаа

Сэдвийн зорилго: Олон улсын харилцаа нь нийгмийн амьдралд хэрхэн холбогдох, түүний онцлог, олон улсын тухай ойлголт болоод түүний хэлбэр, бүрдүүлэгч гол элементүүдийн талаар цэгцтэй мэдлэг олж авахад оршино.

# Түлхүүр үгс:

- **Идеализм**
- **Реалист**
- **Плюрализм**
- **Марксизм**
- **Де-факто**
- **Де-юре**
- **НҮБ**

- **Олон улсын харилцаа**

(ОУХ) — дэлхий олон улсын хоорондох хоёр болон олон талт харилцааг судалдаг шинжлэх ухаан юм.

Улс орон, олон улсын байгууллага гээд олон тал оролцоно.


ОУХ арга зүй, улс төр, эдийн засгийн харилцаа, түүх, олон улсын эрх зүй, хүн ам зүй, гүн ухаан, газар зүй, нийгэм судлал, эртний судлал, гэмт хэрэг зүй, сэтгэл зүй, хүйс судлал, соёл судлал, гадаад харилцаа гэх мэт олон судлагдахуунтай.

Олон улсын харилцаа нь даяарчлал, дипломат харилцаа, улсын бүрэн эрхт байдал, олон улсын аюулгүй байдал, байгаль орчны тэнцвэрт байдал, цөмийн үр ашигт хэрэглээ, үндсэрхэг ёс, эдийн засгийн хөгжил, олон улсын санхүү, алан хядлага, гэмт хэргийн бүлэг, хүний аюулгүй амьдрах эрх, гадаад улсын оролцоо, хүний эрх зэрэг гол сэдвээр хэлэлцэж байна.

# Олон улсын харилцааны тухай ойлголт

- Эх үндэс нь

Анх улс хоорондын, үндэстэн дамнасан /utilitar/ гэсэн үгийг Х зуунд анх **Бентам** хэрэглэж байжээ.



# Олон улсын харилцааны үүсэл хөгжил



Орчин үеийн олон улсын харилцааны систем нь 17-р зуунд тухайн үеийн Европын улсуудыг хамарсан 30 жилийн дайн дуусахад хийсэн Вестфалийн гэрээгээр үүсэж, энэ нэрээр Вестфалийн систем гэж нэрлэгддэг. Энэ гэрээнд улсууд найртай сайхан зэрэгцэн хөгжицгөөе гэж тусгаагүй ч энэ гэрээгээр анх удаа бие биенээ төрт улс буюу nation state хэмээн хүлээн зөвшөөрөх тухай ойлголт үүссэн юм.1648 оны Европын хаад, ноёд хутагтуудын өөр хоорондын дайн дуусч олон улсын жишгээр бие биеэ хүлээн зөвшөөрдөг журам тогтоосныг **Вестфалийн зарчим** хэмээн олон улсын харилцааны эхлэл үүссэн гэж үздэг.

# Олон улсын харилцаа, түүний хэлбэрүүд

- **Эдийн засгийн харилцаа** - Олон улсын худалдаа, гадаад хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, хамтарсан үйлдвэр, валютын харилцаа
- **Улс төрийн харилцаа** - Улс хоорондын, гэрээ, хэлэлцээр, элч төлөөлөгч солилцох, төрийн тэргүүний айлчлал, хамтарсан хурал зөвлөгөөн.
- **Соёлын харилцаа** - Боловсрол, спорт, урлаг, шинжлэх ухаан, шашны зэрэг өргөн хүрээний харилцааны цогц юм.

## Олон улсын харилцааны онол.


### Идеализмын онол

Энэ онол нь анх Италийн яруу найрагч Дантегийн зохиолд ажиглагдсан. Энэ онол нь улс хоорондын мөргөлдөөнийг багасгах, хамтын ажиллагааг хөгжүүлэх үзэл санааг дэвшүүлдэг. Дэлхийн 2-р дайны жилүүдэд их нөлөөтэй байсан онол юм.



## Реалист онол

Уг онолын эх суурийг Италийн сэтгүүлч, улс төрч Н.Макиавелли тавьсан. Олон улсын харилцааны мөн чанар бол тусгаар улсуудын өөрийгөө хамгаалах, сонирголоо хөгжүүлэх эрмэлзэл, өрсөлдөөн, түүний тэнцвэр зэргээр тодорхойлогдоно. Гадаад бодлогод сонирхол түүнийг хэрэгжүүлэх бололцоо хоёрыг нарийн тооцох хэрэгтэй гэж үздэг.




## Плюрализм онол

Орчин үеийн дэлхий ертөнцөд улс орнууд өөр хоорондоо нягт холбогдон харилцан хамааралтай болсон.


Улс орнуудын хамтын ажиллагааны оновчтой аргуудыг илэрхийлэх нь нийт хүн төрөлхтнийг хамарсан хөгжил дэвшлийг гаргах чухал хүчин зүйл мөн.

## Марксизм


Дэлхий даяар пролетарийн хувьсгал хийх аргыг ашиглан ангийн ялгаа, хувийн өмчийг устгавал үндэстний засгийн газар, үндэстэн улсын хэрэг үгүй болно гэж үзжээ. Тэд олон улсын харилцааг улс орны баян ядуугийн тэмцэл гэж үзсэн.



## Олон улсын харилцааны субъектууд



# Олон улсын харилцаанд оролцогчид



Манай улс дэлхийн бүх улстай төрийн байгууллагын төлөөллөөрөө дамжуулан шууд харилцах, олон улсын үйл хэрэгт идэвхтэй оролцох нь олон улсын харилцааны үндсэн оролцогчийн эрх үүрэг юм. Энэ нь Монгол улсын төр, эдийн засаг, дипломат хийгээд зөөлөн хүчний бодлогын зорилго, үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Улсууд үүрэг болон үйл ажиллагааны чиглэл, нөлөөгөөрөө эрх тэгш харилцаж, оролцож байдаг.

## Монгол улсын олон улсын харилцаанд оролцох үүрэг, үйл ажиллагааны чиглэл

**ОУХ-нд оролцох үүрэг**

Олон улсын төр, эрх зүй, эдийн засаг, соёлын зэрэг олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөгөөр тодорхойлогдоно.

**ОУХ-нд оролцох үйл ажиллагааны чиглэл**

ОУХ-нд улс төр, эрх зүй, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагааны чиглэлээр оролцдог.

**ОУХ-нд оролцох нөлөө**

Монгол улс бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавх, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх явдал юм.

# Улс оролцогч

Улс оролцогчийг Де-факто, Де-юре хоёр хэлбэрээр хүлээн зөвшөөрдөг.

Де факто гэдэг нь латин үг бөгөөд ”баараг хууль ёсны” гэсэн утгатай. Олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр юм.

Энэ хүлээн зөвшөөрөл нь тухайн улсад бүрэн итгэл хүлээлгэхгүй байгаагийн илрэл бөгөөд цаашид бүрэн хэмжээнд зөвшөөрөхийн эхлэл байж болно. Тухайлбал, Монгол улс бүрэн эрхт улсын хувьд олон улсын эрх зүйн хүрээнд де факто улс байх статусыг 1961 он хүртэл эдэлж байв.

Де-юре гэдэг нь латинаар хууль ёсны гэсэн утгатай бөгөөд олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрөх хэлбэр юм. 1961 онд НҮБ-ын гишүүнээр элссэн нь манай улс олон улсын хэмжээнд бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн эрхт улс болж олон улсын харилцааны үндсэн оролцогч болсон юм.



**ОУХ-ны улс бус оролцогч гэдэгт:** Засгийн газрын оролцоо, дэмжлэггүйгээр улс үндэстэн дамнасан янз бүрийн оролцогчид, олон улсын байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагааг голчлон авч үздэг. Үндэстэн дамнасан корпораци (ҮДК) нь үйл ажиллагаагаараа олон улсын шинж чанартай, гадаадад хөрөнгөтэй үндэсний компани юм. Олон улсын төрийн бус байгууллагууд (ОУТББ) нь олон улсын засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрээр үүсгэн байгуулагдаагүй ашгийн бус 2-оос дээш улсаас хандив авч, үйл ажиллагаа явуулдаг аливаа олон улсын байгууллагыг хэлнэ. Эдгээр нь голчлон хүмүүнлэгийн болон шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд түгээмэл байдаг.

## Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны зарчим, тэдгээрийн агуулга:

№	Зарчим	Агуулга
1	Олон тулгуурт байх	Энэ зарчим бол нэг талаас Монгол улсын үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон улс оронтой хамтран ажиллах, нөгөө талаас гадаад харилцааг аль болох олон хэлбэрээр явуулахад оршино.
2	Прагматик байх	Энэ зарчим нь гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах явдал юм.
3	Тэнцвэртэй байх	Энэ зарчим бол стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ шат дарааллыг эрхэмлэсэн, Монгол улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэнэ.
4	Үндэсний эрх ашигт нийцсэн байх	Энэ зарчим нь үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйлчилнэ.

## **Олон улсын харилцаанд оролцогчдын үйл ажиллагааны хамрах хүрээ түвшингээр нь ангилвал:**

- Үндэсний
- Бүс нутгийн
- Дэлхийн

Үндэсний хэмжээний бичил оролцогчид-Улс хооронд зорчиж, үйл ажиллагаа явуулж буй иргэд, аж ахуй нэгж, байгууллага

Олон улсын харилцаанд иргэд хоорондын харилцааг олон улсын иргэний эрх зүй зохицуулдаг.

# Олон улсын харилцаа нь 4 чиглэлтэй байдаг

## • Нэг туйлт тогтолцоо

- 1- Их гүрэн нь үндсэн дүрэм зарчмыг тогтоон хэрэгжүүлж, цэрэг эдийг засгийн хувьд ноёрхоно
- 2- Өөрийн нөлөөнд буй нэгжүүдийн хооронд зөрчилдөөнийг зохицуулна
- 3- Нэгж улсуудын тусгаарлах, бие даах оролдлогыг таслан зогсооно

- **Хоёр туйлт тогтолцоо**

Гол онцлог нь хоёр туйлийн хооронд дайсагнасан өрсөлдөөн байдаг.

- 1- Нөгөө эвсэлтэй тэмцэлдэх, боломжтой бол устгахыг оролддог.
- 2- Өөрийн хүчийг байнга нэмэгдүүлэхийг оролддог. Нөгөө эвсэлийн гишүүнийг өөртөө татах, өөрөөсөө гишүүнээ алдахгүй байх гэх мэт тактик ашиглана.

- **Гурван туйлт тогтолцоо**

1- Нөгөө хоёр талтай аль алинтай нь сайн харилцаатай байх, зөрчил үүсэхээс болгоомжлох.

2- Нөгөө хоёр талын хооронд ойр дотны хамтын ажиллагаа бий болохоос сэргийлэх явдал байдаг.

- **Олон туйлт тогтолцоо**

1-Ноёрхогч шинжтэй болж буй аливаа улс, эвслийг эсэргүүцэх

2-Хүчээ аль болох ихэсгэх, эсвэл хадгалах

3-Аль нэг талтай дайтсан ч системийг бүхэлд нь тогтворгүйлэх хэрэггүй.

# Олон улсын хамтын нийгэмлэг

- НҮБ бол тусгаар бие даасан улсуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн эдийн засаг, нийгмийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх, энх тайвныг сахин хамгаалахын төлөө аажмаар ажилладаг олон улсын байгууллага юм.



## НҮБ-ын үндсэн зарчмууд

- Энх тайван, аюулгүй байдлыг сахих
- Үндэстэн хооронд найрамдалт харилцааг хөгжүүлэх
- Дэлхий нийтийн чанартай асуудлуудад хамтран ажиллах
- Үндэстнүүдийг үйл ажиллагааг нэгтгэх

## НҮБ-ын үндсэн зорилтууд

- Дайн дэлхийд энх тайвныг сахих хамгаалах
- Үндэстэн, ард түмний хооронд нөхөрсөг харилцааг хөгжүүлэх
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэнцэх, өвчин, өлсгөлөн, ядуурлыг бууруулах
- Гишүүн орнуудынхаа тавьж буй зорилтыг хэрэгжүүлэхэд туслах

# Монгол болон НҮБ

- Монгол Улс 1961 онд НҮБ-д гишүүнээр элсээд өнгөрүүлсэн жаран жилд НҮБ болон Монгол Улс хоорондын харилцаа нь батжин бэхжиж харилцан үр ашигтай түншлэлийн харилцаа болон төлөвшсөн. Монгол Улс дахь НҮБ нь ардчилсан засаглал, хүний эрх, нийгэм, эдийн засгийн хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, улмаар дасан зохицох, байгаль орчныг хамгаалах зэрэг олон салбарыг хамарсан хөгжилд хувь нэмэр оруулж буй НҮБ-ын системийн 11 байгууллагаас бүрддэг

- **Хамтын ажиллагааны чиглэл зорилго:** НҮБ –ын Дүрмийн зорилго, зарчмуудыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх, байгууллагад хуримтлагдсан оюуны чадавхи, мэдээллийг эдийн засаг, нийгмийнхээ хөгжилд ашиглах
- **Хамтын ажиллагааны хэлбэр:** НҮБ-ын Ерөнхий Ассамблей (ЕА)-н чуулгануудад оролцож, Засгийн газрынхаа бодлого, байр суурийг илэрхийлж, тэдгээрийг зохицуулах, шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах.

# Хамтран ажиллаж буй тодорхой чиглэлүүд

- Ядуурлыг бууруулж, нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах /Мянганы хөгжлийн зорилтуудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх/
- Нийгмийн хөгжил дэх хоршооллын үүрэг ролийг бэхжүүлэх
- Бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгахад тус дөхөм үзүүлэх
- Далайд гарцгүй орнуудын байдлыг сайжруулах
- Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулах
- Шинээр болон сэргээн тогтоосон орнуудын ардчиллыг дэмжих, хувь нэмэр оруулах.

# НҮБ –ын үндсэн гол байгууллагууд

## Ерөнхий ассамблей

- Дэлхийн бараг бүх үндэстний төлөөлөгчдөөс бүрддэг ба улс орнууд өөрсдийн үзэл бодол, дуу хоолойг дэлхийн бусад орнуудад хүргэх талбар юм. Гишүүн улс бүр том бага, баян ядууг үл харгалзан нэг саналын эрхтэй оролцдог.



# Аюулгүйн зөвлөл

- НҮБ-ын Дүрмийн 24 дүгээр зүйлд заасаны дагуу олон улсын энхтайван, аюулгүй байдлыг хангах бөгөөд НҮБ-д шинээр гишүүн элсүүлэх, НҮБ-ын Хартид оруулах аливаа өөрчлөлтийг батлах зэрэг үүрэгтэй.



# Эдийн засаг, нийгмийн зөвлөл

- Эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэндийн асуудлаар үйл ажиллагаа явуулахаар заагдсан байдаг ч ихэнхдээ дэргэдээ байх Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO) зэрэг тусгай байгууллагуудаар дамжуулан явуулдаг.

Бүтэц: 53 улсыг жил тутам гуравны нэг нь шинэчлэгдэхээр 3 жилийн хугацаагаар сонгоно.

# Нарийн Бичгийн Даргын Газар

- Аль нэг улс орны нөлөөнд авталгүй дундыг баримтлан НҮБ-ын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байгууллага юм. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга удирддаг.



# Олон Улсын Шүүх

- НҮБ-ын Олон улсын шүүх нь 1945 онд байгуулагдсан ба Нидерландын Гааг хотод байрлана. Үйл ажиллагаагаа 1946 оноос эхэлсэн байна.
- Зорилго нь улс хооронд гарсан маргааныг таслан шийдвэрлэх юм.
- Шүүхээр дайны гэмт хэрэг, улсын дотоод хэрэгт хууль бусаар хөндлөнгөөс оролцох, үндэстний хомроголон устгах зэрэг асуудлуудыг шүүн хэлэлцэнэ.



# Асрамжийн зөвлөл

- Асрамжийн зөвлөл 1994 онд татан буугдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилгоос үүдэн асрамжийн тогтолцоо нь дараах гол зорилттой болно олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх асрамжийн нутаг дэвсгэрийн хүн амын улс төр, эдийн засаг, нийгэм, боловсролын хөгжил дэвшилд дөхөм үзүүлэх, тухайн нутаг дэвсгэрийн болон хүн амын онцлог нөхцөл байдал, хүн амынх нь чөлөөтэй илэрхийлсэн хүсэл зориг, асрамжийн тухай холбогдох хэлэлцээр тус бүрийн заалтыг тус тус харгалзан үзэх үндсэн дээр өөрийгөө удирдах ёсыг тогтоох буюу тусгаар тогтнох дэвшилтэт хөгжилд нь нэг адил дөхөм үзүүлэх

# НҮБ-н төрөлжсөн байгууллагууд

- Олон усун атомын Эрчим хүчний агентлаг • Ерөнхий Ассамблей, эдийн засаг нийгмийн зөвлөлийн туслах байгууллагууд орно.
- 1. НҮБ-н худалдаа хөгжлийн бага хурал
- 2. Хүрээлэн орчны хөтөлбөр
- 3. Хөгжлийн хөтөлбөр
- 4. Хүүхдийн сан
- 5. Хүн амын сан




## Хяналтын асуулт, даалгавар:

1. НҮБ-ын төрөлжсөн буйгууллага, түүний зорилго?
2. Нөгөө эвсэлтэй тэмцэлдэх, боломжтой бол устгахыг оролддог тогтолцоог юу гэж нэрлэдэг вэ?
3. Олон улсын харилцааны оролцогчдын бага улс ямар үүрэг зорилготой вэ?
4. ОУХ-нд оролцох үйл ажиллагааны ямар чиглэл баримталдаг вэ?

## Эх сурвалж:

1. “Нийгэм судлал” хичээлийн ерөнхий боловсролын сурах бичгүүд
2. Д.Буян “Нийгмийн тухай мэдлэг”. УБ., 2011
3. Б.Амгаланбаяр, Т.Сайхнаа “Хичээлүүдийн лавлах”. УБ., 2014



**Анхаарал хандуулсанд баярлалаа.**

